



## МОНГОЛ ШИЛТГЭЭН ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 23/01

Улаанбаатар хот

┌ Үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг батлах ┐

Монгол Улсын компанийн Компанийн тухай хуулийн 62.1.9 дэхь заалт, "Монгол шилтгээн" ХК-ийн 2023 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. "Монгол шилтгээн" ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хангалттай хэмээн үзсүгэй.
2. "Монгол шилтгээн" ХК- нь 2022 онд ногдол ашиг хувиарлахгүй байхаар тогтоосон ТУЗ-ийн шийдвэрийг зөвшөөрсүгэй.
3. Компанийн үйл ажиллагааг идэвхжүүлж ажиллахыг ТУЗ-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



/Ч.АМАРБААТАР/



## МОНГОЛ ШИЛТГЭЭН ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 23/02

Улаанбаатар хот

«Их хэмжээний хэлцэл хийх»

зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.3, 62.1.10 дахь заалт, 87-р зүйлийн 87.1, 88-р зүйлийн 88.2 дахь заалт болон "Монгол шилтгээн" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2023.04.30-ны өдрийн тооллогын комиссын тогтоолыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. "Монгол шилтгээн" ХК-ийн хуримтлагдсан 2.500 000 000 / Хоёр аравны таван тэр бум / төгрөгийн өрийг хувьцаанд хөрвүүлэх нэгж хувьцааны үнийг 290 төгрөгөөр тогтоосугай.
2. "Хэлцэл хийхийн өмнөх улирлын сүүлийн балансын активын нийт дүнгийн 25% - аас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл" зэрэг их хэмжээний хэлцэл хийхийг зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



/Ч.АМАРБААТАР/



## МОНГОЛ ШИЛТГЭЭН ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 23/03

Улаанбаатар хот

«Компанийн өрийг хувьцаанд»

хөрвүүлэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 25-р зүйл, "Монгол шилтгээн" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2023.04.30-ны өдрийн тооллогын комиссын тогтоолыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2.500 000 000 / Хоёр аравны таван тэрбум / төгрөгийн өрийг хувьцаагаар солихыг зөвшөөрсүгэй.
2. Өрийг хувьцаагаар солих төслийг хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



/ Ч.АМАРБААТАР /



МОНГОЛ ШИЛТГЭЭН ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 23/04.

Улаанбаатар хот

「Тэргүүн ээлжид худалдан」

авах давуу эрхээ хувьцаа олгох тухай

МУ-ын Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.8, заалт болон 25-р зүйлийн 25.6-дахь заалтыг тус үндэслэн "Монгол шилтгээн" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2023.04.30-ны өдрийн тооллогын комиссын тогтоолыг үндэслэн

**ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2.500 000 000 / Хоёр аравны таван тэрбум / төгрөгийн өрийг хувьцаагаар солихоор нэмж гаргасан хувьцааг хувьцаа эзэмшигч нарт тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхийг эдлүүлсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



/ Ч.АМАРБААТАР /



## МОНГОЛ ШИЛТГЭЭН ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 23/05

Улаанбаатар хот

᠎ Компанийн ТУЗ-ийн гишүүдийг ᠎

сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, дахь заалт болон “МОНГОЛ ШИЛТГЭЭН” ХК-ийн 2023 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын тогтоолыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 6 хүнийг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр улируулан сонгосугай.

1. Ч.Амарбаатар
2. М.Ган-Эрдэнэ
3. Г.Ганчимэг
4. Д.Дагвадорж
5. Г.Мөнхбилэг
6. Б.Билгүүн

2. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 3 хүнийг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр улируулан сонгосугай.

1. Ж.Жаргалсайхан
2. М.Отгонбаатар
3. Д.Чанцал

3. Компанийн тухай хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



/Ч.АМАРБААТАР/



## МОНГОЛ ШИЛТГЭЭН ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 23/06.

Улаанбаатар хот

*Компанийн дүрэмд өөрчлөлт*

*оруулах тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 17-р зүйлийн 1дэх хэсэг, "Монгол шилтгээн" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2023.04.30-ны өдрийн тооллогын комиссын тогтоолыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн өрийг хувьцаанд хөрвүүлснээр "Монгол шилтгээн" ХК нь нэг бүр нь 290 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 18 620 690 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ.
2. Санхүүгийн зохицуулах хорооноос компанийн өрийг хувьцаанд хөрвүүлэх шийдвэр гарсан өдрөөс эхлэн төсөл бүрэн хэрэгжиж, хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлж, компанийн хувьцааны бүртгэл, үнэт цаасны бүрдүүлбэр, дүрэмд орсон өөрчлөлтүүдийг холбогдох төрийн эрх бүхий байгууллагуудад зохих журмын дагуу бүртгүүлсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



/Ч.АМАРБААТАР/